

## МУИС-ийн оюутнуудын дундах “Компьютерийн сүлжээний олимпиад 2020”

МУИС-ийн ХШУИС-ийн Компьютерийн сүлжээ хөтөлбөрөөс жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Компьютерийн сүлжээний олимпиад 2020” 2020 оны 12-р сарын 23-аас 28-ны өдрүүдэд МУИС-ийн оюутнуудын дунд цахим хэлбэрээр зохион байгуулагдах гэж байна. Энэхүү олимпиадад зөвхөн МУИС-ийн оюутнууд оролцох боломжтой юм.

Олимпиадад бүртгүүлэхдээ дараах гурван түвшний аль нэгийг сонгон бүртгүүлэх бөгөөд түвшин бүрийн агуулгад тохирсон бодлогыг бодож, өрсөлдөнө:

- 2-р түвшин: “Өгөгдлийн холбоо”
- 3-р түвшин: “Компьютерийн сүлжээний төхөөрөмж”
- 4-р түвшин: “Компьютерийн сүлжээний аюулгүй байдал”

Олимпиад нь хоёр үе шаттай явагдах бөгөөд хоёрдугаар шатанд түвшин бүрээс босго оноог хангасан, эхний 20 хүртэлх оюутан дараагийн шатанд оролцох эрхтэй болно.

### Хамрах хүрээ:

Уг олимпиадад МУИС-ийн II, III, IV-р түвшний оюутнууд оролцох боломжтой юм.

### Бүртгэл:

1. Дараах QR code-ийг ашиглан бүртгүүлэх
2. <http://tinyurl.com/net-olympiad> хаягаар орж бүртгүүлэх

Дэлгэрэнгүй асууж тодруулах зүйл байвал доорх утсаар болон и-мэйл хаягаар холбоо барина уу.



Холбоо барих:

и-мэйл: [telmuun@seas.num.edu.mn](mailto:telmuun@seas.num.edu.mn)

Утас: 97007799